



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 2/21

Улаанбаатар хот

Бүжгийн спортын тэмцээнийг зохион байгуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Монгол Улсын “Биеийн тамир, спортын тухай” хууль, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын аварга шалгаруулах Бүжгийн спортын тэмцээнийг 2017 оны 05 дугаар сарын 02-ны өдөр “Буянт-Ухаа” спортын ордонд зохион байгуулсугай.

2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 1.200.000 /нэг сая хоёр зуун мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны спортын уралдаан тэмцээний төсвийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.

4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг мэргэжилтэн /Э.Мөнх-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.


ДАРГА



Ж.ГАНБОЛД

1150500052

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны
даргын 2017 оны ...*03.09.2017*... сарын *27*-ны өдрийн
А.Мөнх-Эрдэнэ дугаар тушаалын нэгдүгээр хавсралт




Бүжгийн спортын тэмцээнийг
зохион байгуулах төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Тамирчдын шагнал: 10 x 10.000 төг = 100.000 төг 10 x 8.000 төг = 80.000 төг 10 x 6.000 төг = 60.000 төг	240.000
2.	Шүүгчдийн зардал: /12 хүн x 1 өдөр x 20.000 төг/	240.000
3.	Заал талбайн зардал	400.000
4.	Өргөмжлөл	80.000
5.	Медаль:	240.000
	ДҮН:	1.200.000

Боловсруулсан:
Мэргэжилтэн *А.Мөнх-Эрдэнэ* Э.Мөнх-Эрдэнэ

Хянасан:
Нягтлан бодогч О.Эрдэнэцэцэг

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны
даргын 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн
... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Бүжгийн спортын тэмцээний
шүүгчдийн бүрэлдэхүүн

- | | |
|------------------|---------------|
| 1. Ерөнхий шүүгч | О.Мөнгөнхуяг |
| 2. Нарийн бичиг | Г.Мөнхцэцэг |
| 3. Шүүгч | О.Саранхүү |
| 4. Шүүгч | Д.Ганцог |
| 5. Шүүгч | Б.Батсайхан |
| 6. Шүүгч | А.Амармэнд |
| 7. Шүүгч | Б.Сэлэнгэ |
| 8. Шүүгч | С.Ууганбаяр |
| 9. Шүүгч | Н.Тэмүүлэн |
| 10. Шүүгч | О.Ганбаяр |
| 11. Шүүгч | Н.Мөнх-Эрдэнэ |
| 12. Шүүгч | О.Оюунбат |